



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Халхгол сумын Сум дундын ойн ангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2025/129/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2025 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.24 № А39
танай 2025.01.24-ны № 1 -т

ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН
СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН
ДАРГА Л.ҮРЖИНДОРЖ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Халхгол сумын Сум дундын ойн ангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Тайлант жилд нийгмийн даатгалын систем шинэчлэгдэж, төрийн алба хаагчдын цалингийн нэгдсэн системд ажил мэргэжлийн код болон даатгуулагчийн кодыг зөрүүтэй оруулснаас ажилтнаас илүү дутуу шимтгэл суутгах, байгууллагаас төлөх шимтгэлийн хэмжээг илүү дутуу тооцоолсноос шалтгаалан жилийн эцэст авлага, өр төлбөр үүсэж тайланд залруулгууд хийгдсэн байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

011022037

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Халхгол сумын Сум дундын ойн ангийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилго, 8 зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Засаг даргын тамгын газраас 81.4 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,240,000.00	31,330,182.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,240,000.00	31,330,182.00
354	Хангамжийн материал	2,240,000.00	31,330,182.00
35410	Бичиг хэргийн материал	250,000.00	217,000.00
35420	Аж ахуйн материал	60,000.00	350,850.00
35470	Бусад хангамжийн материал	1,930,000.00	30,762,332.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,000,000.00	147,190,625.62
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,000,000.00	147,190,625.62
392	Биет хөрөнгө	-	146,290,625.64
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	118,416,667.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(16,151,041.68)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	48,916,667.00
39208	Бусад үндсэн хөрөнгө элэгдэл	-	(4,891,666.68)
393	Биет бус хөрөнгө	1,000,000.00	899,999.98
39301	Программ хангамж	1,000,000.00	1,000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(100,000.02)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,240,000.00	178,520,807.62
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,564.95	282,135.68
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,564.95	282,135.68
413	Өглөг	3,564.95	282,135.68
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,564.95	282,135.68
41312	НДШ-ийн өглөг	3,564.95	282,135.68
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,236,435.05	178,238,671.94
51	Засгийн газрын хувь оролцоо	3,236,435.05	178,238,671.94
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	3,236,435.05	3,236,435.05
51210	Өмнөх үеийн үр дүн		
51220	Тайлант үеийн үр дүн	3,236,435.05	175,002,236.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,240,000.00	178,520,807.62

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	74,473,600.00	293,500,266.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,000,000.00	199,915,666.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,000,000.00	199,915,666.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,000,000.00	3,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000.00	3,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	167,333,334.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	29,582,332.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	71,473,600.00	93,584,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага/	71,473,600.00	93,584,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	71,237,164.95	118,498,029.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	71,237,164.95	118,498,029.11

Дорнод аймгийн Халхгол сумын Сум дундын ойн ангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	70,085,827.50	116,607,139.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	56,551,250.56	75,587,710.26
210101	Үндсэн цалин	47,141,272.01	61,572,000.00
210102	Нэмэгдэл	5,679,278.55	14,015,710.26
210104	Урамшуулал	3,730,700.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,060,476.94	9,263,570.73
210201	Тэтгэврийн даатгал	4,806,856.29	6,437,083.27
210202	Тэтгэмжийн даатгал	565,512.52	695,435.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	452,410.03	480,296.35
210204	Ажилгүйдлийн даатгал	104,673.07	275,085.21
210205	Эрүүл мэндийн даатгал	1,131,025.03	1,375,669.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	750,000.00	2,250,000.00
210302	Түлш, халаалт	750,000.00	2,250,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,254,200.00	6,641,150.00
210401	Бичиг хэрэг	264,200.00	314,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,300,000.00	5,607,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	170,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	520,000.00	480,150.00
2107	Томилолт, зочны зардал	1,108,000.00	976,000.00
210702	Дотоод албан томилолт	1,108,000.00	976,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	361,900.00	398,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	361,900.00	398,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		21,142,708.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,151,337.45	1,890,889.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,151,337.45	1,890,889.74
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,151,337.45	1,890,889.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	3,236,435.05	175,002,236.89
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	3,236,435.05	175,002,236.89

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	74,473,600.00	96,584,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,000,000.00	3,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,000,000.00	3,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,000,000.00	3,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	71,473,600.00	93,584,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	71,473,600.00	93,584,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	71,473,600.00	93,584,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	74,473,600.00	96,584,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	74,473,600.00	96,584,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	73,322,262.55	94,693,710.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	56,551,250.56	75,587,710.26
210101	Үндсэн цалин	44,600,000.00	61,572,000.00
210102	Нэмэгдэл	8,475,838.06	14,015,710.26
210103	Урамшуулал	3,475,412.50	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,056,911.99	8,985,000.00
210201	Тэтгэврийн даатгал	4,803,291.34	6,109,800.00

Дорнод аймгийн Халхгол сумын Сум дундын ойн ангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	565,512.52	718,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	452,410.03	359,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	104,673.07	359,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,131,025.03	1,437,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,500,000.00	1,500,000.00
210302	Түлш, халаалт	1,500,000.00	1,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,384,200.00	6,647,000.00
210401	Бичиг хэрэг	314,200.00	300,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,300,000.00	5,607,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	170,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,108,000.00	976,000.00
210702	Дотоод албан томилолт	1,108,000.00	976,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,200,000.00	398,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,200,000.00	398,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	-	398,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1521900	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,521,900.00	600,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,521,900.00	600,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,151,337.45	1,890,889.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,151,337.45	1,890,889.74
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	<u>3,236,435.05</u>	<u>3,236,435.05</u>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	3,236,435.05	3,236,435.05
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн			175,002,236.89	175,002,236.89
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	<u>178,238,671.94</u>	<u>178,238,671.94</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	-	-
71403	Ойжуулалт	96,584,600.00	94,693,710.26	1,890,889.74
12	Татварын бус орлого	3,000,000.00	3,000,000.00	
12004	Төсөвт байгууллагын өөрийн орлого үндсэн	3,000,000.00	3,000,000.00	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	96,584,600.00	94,693,710.26	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	96,584,600.00	94,693,710.26	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	96,584,600.00	94,693,710.26	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	96,584,600.00	94,693,710.26	1,890,889.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	96,584,600.00	94,693,710.26	1,890,889.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	76,814,600.00	75,587,710.26	
210101	Үндсэн цалин	61,572,000.00	61,572,000.00	
210102	Нэмэгдэл	15,242,600.00	14,015,710.26	1,226,889.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,985,000.00	8,985,000.00	
210201	Тэтгэврийн даатгал	6,109,800.00	6,109,800.00	
210202	Тэтгэмжийн даатгал	718,800.00	718,800.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	359,400.00	3,594,000.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	359,400.00	359,400.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	1,437,600.00	1,437,600.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,500,000.00	1,500,000.00	
210302	Түлш, халаалт	1,500,000.00	1,500,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	6,767,000.00	6,647,000.00	120,000.00
210401	Бичиг хэрэг	300,000.00	300,000.00	
210402	Тээвэр, шатахуун	5,607,000.00	5,607,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	360,000.00	240,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	500,000.00	
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	976,000.00	24,000.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	976,000.00	24,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	918,000.00	398,000.00	520,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	-	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	180,000.00	-	180,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	90,000.00	-	90,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	398,000.00	398,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	600,000.00	600,000.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	600,000.00	600,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ			
2132	Бусад урсгал шилжүүлэг			
26	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,890,889.74	1,890,889.74

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР			
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ			
131001	Улсын төсвөөс санхүүжих	96,584,600.00		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			
62	АЖИЛЛАГСДЫН ТОО		5	5
620001	Удирдах ажилтан		1	1
620002	Гүйцэтгэх ажилтан		4	4
620003	Үйлчлэх ажилтан		0	0

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
81703	Ойжуулалт	96,584,600.00	96,584,600.00	
80101	Үндсэн үйл ажиллагаа	96,584,600.00	96,584,600.00	
80112	Нийтлэг үйлчилгээ			
12	Татварын бус орлого			
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого үндсэн	3,000,000.00	3,000,000.00	
122005	Төсвөөс санхүүжих	93,584,600.00	93,584,600.00	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	96,584,600.00	96,584,600.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	96,584,600.00	96,584,600.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	96,584,600.00	94,693,710.26	
2103	БАЙР АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ	1,500,000.00	1,500,000.00	
210301	Гэрэл, цахилгаан			
21302	Түлш халаалт	1,500,000.00	1,500,000.00	
21303	Цэвэр, бохир ус			
26	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,890,889.74	1,890,889.74
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,890,889.74	1,890,889.74

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 1.5 сая төгрөгийн зөрчил¹-д 1.5 сая төгрөгийн 2 албан шаардлага, хүргүүлээ.

5.1 Албан шаардлага

1. Томилолтын зардлыг удирдамж албан бичиг үндэслэх баримтгүй 1.0 сая төгрөгийг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Анхан шатны баримтын иж бүрдэлгүй, дэмжих баримтгүй материалын үнэ гэсэн гүйлгээний утгаар 0.5 сая төгрөгийн зардал гаргаж бүртгэлд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Томилолтын зардлыг удирдамж албан бичиг үндэслэх баримтгүй олгосон	1	976.0			1	976.0							
Анхан шатны баримтын иж бүрдэлгүй, дэмжих баримтгүй материалын үнэ гэсэн гүйлгээний утгаар зардал гаргаж бүртгэлд тусгасан	1	558.0			1	558.0							
Дүн	2	1,534.0			2	1,534.0							

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Тайлант хугацаанд шилэн дансны цахим системд 1 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.	1	-						1	-
Нийт дүн	1	-						1	-



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 132/19125799
АВА - 2025/129/НА-СТ#ТМБ

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халхгол сумын Сум дундын ойн ангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр 976,000.00 төгрөгийг байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэр, баталсан төсөвгүй олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 42 дугаар зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "Анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог, 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам" -ын 2.5.-д "Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчийн байр, хоол, унааны зардлын төсвийг байгууллагын эрх бүхий албан тушаалтан батална", 2.6-д "Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчид томилолтоор ажиллуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр, батлагдсан зардлын төсвийг үндэслэн томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөрийг урьдчилан олгоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1 дэх "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг үндэслэн батлагдсан төсвийн хүрээнд ажил гүйлгээг хийх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2125040279

2. Холбогдох хууль тогтоомж, журам, шийдвэрийг баримтлан ажиллахыг Халхгол сумын Сум дундын ойн ангийн дарга Л.Үржиндорж, нягтлан бодогч Д.Дулмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР



И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э.НАНДИНЧИМЭГ





ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 133/1902/5749
ААА-2025/1291/НА-СТА-Тулс

Чойбалсан хот

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халхгол сумын Сум дундын ойн ангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримтын иж бүрдэлгүй, дэмжих баримтгүй материалын үнэ гэсэн гүйлгээний утгаар 558,000.00 төгрөгийн зардал гаргаж бүртгэлд тусгасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 42 дугаар зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, Төсвийн ерөнхий ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан балансын гаргалт, тооллого тооцоо, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг өөрийн болон харъяа байгууллагадаа байнга шалган зааварчилж байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "Анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог, 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1 дэх "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, иж бүрэн анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээ хийх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2125040281

2. Холбогдох хууль тогтоомж, журам, шийдвэрийг баримтлан ажиллахыг Халхгол сумын Сум дундын ойн ангийн дарга Л.Үржиндорж, нягтлан бодогч Д.Дулмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР



И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э.НАНДИНЧИМЭГ

